



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/47

Төмөрбулаг сум

Газар эзэмшүүлэх эрх олгох дуудлага  
худалдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоол, 2024 оны 136 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх олгох дуудлага худалдааг явуулах 2 нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, дуудлага худалдаа явуулах товын хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг явуулах бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар зохион байгуулж ажиллахыг Газрын Харилцаа, Барилга хот байгуулалтын газрын Төлбөр, татвар үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн ( Б.Батмөрөн )-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Энхбаяр)-т хариуцуулсугай.

ДАРГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ

Засаг даргын 2024 оны 05 сарын 24-ны өдрийн  
А/47 дугаар захирамжийн хавсралт

Төмөрбулаг суманд газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны газры байршил, эзэмших хугацаа, хэмжээ,  
зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, явуулах хугацаа

№	Эзэмшүүлэх газрын байршил	Газар эзэмшүүлэх зориулалт	Газар эзэмшүүлэх хугацаа	Эзэмшүүлэх газрын хэмжээ / м <sup>2</sup> /	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ /төг/	Дэнчингийн үнэ /төг/	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Дуудлага худалдаа явуулах хугацаа
1	4-р баг Тал бүлгийн түрүү	Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	15	100000	583000	58300	3831044	2024.06.25 өдрийн 9 цаг 00 минут- 15 цаг 00 минут
2	5-р баг Хаан банкны баруун талд	Банк санхүүгийн байгууллага	15	400	320000	32000	3831049	2024.06.25 өдрийн 9 цаг 00 минут- 15 цаг 00 минут
Дүн				100400				